


ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК

2024 | жилийн
тайлан



АЛСЫН ХАРАА

Цахилгаан дамжуулах үндэсний “УХААЛАГ” сүлжээ болох.




НЭГДСЭН СТРАТЕГИ ҮР ДҮН

Чадварлаг хүний нөөц, дэвшилтэт техник технологи бүхий үндэсний дамжуулах сүлжээ болно



ЭРХЭМ ЗОРИЛГО

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулна.




ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ Мэдлэг, ур чадвар, хүний хөгжил
- ✓ Аюулгүй байдал
- ✓ Багаар ажиллах
- ✓ Шинэ санаа, бүтээлч сэтгэлгээ
- ✓ Шударга, хариуцлагатай байдал
- ✓ Компанийн нэр төр

ТАНИЛЦУУЛГА

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж бүхий стратегийн ач холбогдол бүхий 100 хувь төрийн өмчит хаалттай хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 66 хувийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34 хувийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн Газраас эрх олгосон төрийн байгууллага эзэмшдэг.



ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Байгуулагдсан он:

1967

Салбар:

5

Ажилтны тоо:

1307

ЦДАШ-ын нийт трассын урт:

5653,6 км

220 кВ-ын ЦДАШ-ын трассын урт

2294,1 км

110 кВ-ын ЦДАШ-ын трассын урт

3346,1 км

35 кВ-ын ЦДАШ

13,4 км

Нийт дэд станцын тоо:

84

220 кВ-ын дэд ЦДАШ

11

110 кВ-ын дэд ЦДАШ

73

Хамрах хүрээ:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн 66 хувь /1.033.00 км²/, хүн амын 72 хувийг хамарч, Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Баянхонгор, Төв, Дорноговь, Дундговь, Хэнтий, Говьсүмбэр, Өмнөговь, Сүхбаатар, Завхан зэрэг аймгуудын 300 гаруй сум суурин газар

Дамжуулсан ЦЭХ: 8,024.7 сая кВт.цаг

Тусгай зөвшөөрлүүд:

- Цахилгаан дамжуулах,
- Цахилгаан импортлох (БНХАУ-аас),
- Эрчим хүчний барилга байгууламж-80 МВт-ын эрчим хүчний хуримтлуурын систем барих
- 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын, засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх,
- 4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах,
- Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх,
- Харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх
- Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах

УЛААНБААТАР САЛБАР

Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан, Налайх, Багахангай дүүргүүд, Төв аймгийн Баянчандмань сум



ЦДАШ

897,72 км



ДС

34

2475 МВА



220 кВ ЦДАШ

110 кВ ЦДАШ

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Төв аймгууд



ЦДАШ

1062,46 км



ДС

12

729,2 МВА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

2024 он бол бидний хувьд түүхэн бүтээн байгуулалтыг өрнүүлж, аюулгүй ажиллагааг дээдлэн, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, зорилго зорилтоо давуулан биелүүлсэн амжилт бүтээлээр дүүрэн жил байлаа.

Тайлант онд 2,541.2 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг импортоор авсан нь өмнөх онтой харьцуулахад 374.6 сая кВт.цаг буюу 17.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эрчим хүчний системийн оргил үеийн ачаалал өмнөх жилээс 19 МВт-р нэмэгдэж, 2024 оны 12 сарын 26-ны өдөр 1,655 МВт-д хүрсэн.

Манай компани Цэвэрлэх, Баянхонгор, Өндөрхаан, Даланзадгад, Мөрөн дэд станцуудын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг амжилттай хэрэгжүүлж, суурилагдсан хүчин чадлыг 126.3 МВА-гаар нэмэгдүүлэв. 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 110/10 кВ-ын 40 МВА хүчний трансформаторын их засвар, 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын реле хамгаалалт, автоматикийн бүрэн шинэчлэлийг хийж дуусгалаа. Мөн E-zone портал системийг ТЗБАХ-ээр дамжуулан амжилттай нэвтрүүлж, хэвийн горимын хяналт, мэдээллийн удирдлагын системийг сайжруулан 72 дэд станцыг технологийн сүлжээнд холбон, шуурхай ажиллагааны болон SCADA системд холбогдох боломжийг бүрдүүлэв.


Компанийн цахилгаан хэмжлийн лаборатори нь MNS IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангаж, гэрчилгээ авснаар Монгол улсын эрчим хүчний анхны итгэмжлэгдсэн лаборатори боллоо.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд 220 кВ, 110 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 50 МВт чадалтай Багануур “Батарей хуримтлуурын станц”-ыг Эрчим хүчний нэгдсэн системд системд амжилттай залгаж, тохируулга, зүгшрүүлэлтийг хийлээ. БНХАУ-аас ЦЭХ импортлох 220 кВ-ын “Зэс Оюу” хуваарилах байгууламжийн барилга угсралтад компанийн инженер техникийн ажилтнууд ур чадвараа гарган ажиллаж байна.

Сургалтын чиглэлээр гадны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, JICA-н төслийн хүрээнд 30 ИТА-г гадаад сургалтад хамруулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв. Монгол Улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг хөгжүүлэх (МУТЭХЧХ) төсөл-ийн хүрээнд “Өндөр хүчдэлийн техникч” мэргэжлийн МТБС-ын сургалтын хосмог сургалт зохион байгуулах санамж бичиг GIZ-тэй байгуулж, төслийн ажлыг эхлүүлээд байна.

Компани өмнөх онтой харьцуулахад 2024 онд Монгол Улсын төсөвт 5,108.9 тэрбум төгрөгөөр илүү буюу 94,390.3 сая төгрөг төвлөрүүлэн 550,740.0 сая төгрөгийн орлоготой ажиллахаас 557,152.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөөг 101.2% биелүүлсэн. Мөн төлөвлөгөөт зардлыг 1,8 хувиар, алдагдлын хэмжээг 88,3 хувиар багасгасан нь санхүүгийн үр ашигтай байдалд томоохон ахиц гаргалаа.

Бид эрчим хүчний салбарын тогтвортой байдлын баталгааг хангах үүргээ нэр төртэйгөөр биелүүлж байгаа бөгөөд 2025 онд Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжилд дэмжлэг үзүүлэх жил болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын дамжуулах сүлжээний төлөвлөгөөг боловсруулах, сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг эрчимжүүлэх, ногоон эрчим хүчний оролцоог нэмэгдүүлэх, инноваци шинэ техник технологийг нэвтрүүлэх, 2025 оныг “Салбарын инженер техникийн ажилтан, албан хаагчдын жил”-ээр зарласантай холбогдуулан хүний нөөц чадавх, сургалтын чанарыг сайжруулах зорилтыг дэвшүүлэн төлөвлөсөн ажлуудаа амжилттай хэрэгжүүлэн, эрчим хүчний салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж ажиллах болно.




Б.ДАШДАВАА

“ЦДҮС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын ахлах шинжээч Б.Нармандах, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Л.Отгонжаргал, Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын мэргэжилтэн Г.Гэрэлт-Од, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ТӨХШХ-н ахлах мэргэжилтэн Э.Ганчимэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Г.Дэлгэрмаа, хараат бус гишүүнээр ШУТИС-ийн Судалгаа хөгжүүлэлтийн албаны дарга Ж.Арслан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивын эрхлэгч Л.Одмаа, Л.Долгорсүрэн нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд Компанийн тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэн Эрчим хүчний сайдын удирдамж чиглэлийн дагуу компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, компанийн ажилтнуудад 2023 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлс олгох, компанийн зохион байгуулалтын бүтэц өөрчлөх, ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх, 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын биелэлт, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, гүйцэтгэх захирлын Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан, 2025 оны зардлын төсөв, хороодын тайлан, ногдол ашгийн тухай, төлөвлөгөөний тодотгол, компанийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл зэрэг асуудлаар 15 удаа хуралдаж, 34 асуудлыг хэлэлцэн 29 тогтоол, 22 тэмдэглэл гаргасан.



ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Эрчим хүчний сайдын тушаалаар баталсан 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг мөрдөж ажилласан.

2024 ОНЫ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Харьцуулалт			
							Төлөвлөгөөтэй		Өмнөх оны мөн үетэй	
					Төл	Гүйц	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Дамжуулах цахилгаан эрчим хүч		сая.кВт.ц	7,777.4	8,310.0	8,330.1	20.1	0.2	552.7	7.1
	Дамжуулалтын алдагдал	хувиар	хувь	3.55	3.69	3.67	-0.03	-0.8	0.1	3.2
		биетээр	сая.кВт.ц	276.2	307.0	305.4	-1.6	-0.5	29.2	10.6
	Сонгино хуримтлуур		сая.кВт.ц	0.0	83.4	76.5	-6.9	-8.2	76.5	0.0
	Дамжуулсан цахилгаан эрчим хүч		сая.кВт.ц	7,501.2	7,919.7	8,024.8	105.1	1.3	523.5	7.0
2	Нийт орлого		сая.төг	541,910.8	550,740.0	557,152.0	6,412.1	1.2	15,241.2	2.8
	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	65,735.8	74,120.7	85,345.5	11,224.8	15.1	19,609.6	29.8
		Оюутолгой ХХК гэрээний орлого	сая.төг	458,855.7	458,328.8	442,893.9	-15,434.9	-3.4	-15,961.9	-3.5
		Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	17,319.2	18,290.5	28,912.7	10,622.2	58.1	11,593.5	66.9
3	Нийт зардал		сая.төг	548,566.4	569,797.0	559,386.5	-10,410.5	-1.8	10,820.1	2.0
	Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	85,764.5	105,971.0	106,988.5	1,017.5	1.0	21,224.0	24.7
		Оюутолгой ХХК гэрээний зардал	сая.төг	458,855.7	458,328.8	442,893.9	-15,434.9	-3.4	-15,961.9	-3.5
		Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	3,946.2	5,497.2	9,504.1	4,006.9	72.9	5,557.9	140.8
	Элэгдэл		сая.төг	26,808.3	26,653.8	28,330.6	1,676.8	6.3	1,522.3	5.7
4	Татварын өмнөх ашиг /алдагдал		сая.төг	-6,655.6	-19,057.0	-2,234.4	16,822.6	-88.3	4,421.2	-66.4
	Орлогын татварын зардал		сая.төг	3.9	0.0	3.8	3.8	0.0	-0.1	-3.3
5	Цэвэр ашиг алдагдал		сая.төг	-6,659.5	-19,057.0	-2,238.2	16,818.8	-88.3	4,421.3	-66.4
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал		төг	0.99	0.97	1.00	0.0	3.0	0.0	0.8

7	Нийт авлага		сая.төг	2,773.8	3,163.1	8,346.0	5,182.9	163.9	5,572.2	200.9
	Үүнээс	ЦЭХ	сая.төг	1,286.9	2,402.2	6,003.0	3,600.8	149.9	4,716.1	366.5
		Бусад	сая.төг	806.2	132.6	1,714.7	1,582.1	1,193.2	908.5	112.7
		Урт хугацаат авлага	сая.төг	680.7	628.3	628.3	0.0	0.0	-52.4	-7.7
8	Нийт өглөг		сая.төг	382,394.6	514,925.3	542,095.1	27,169.8	5.3	159,700.5	41.8
	Үүнээс:	Богино хугацаат өглөг	сая.төг	1,476.7	20,008.5	8,955.0	-11,053.5	-55.2	7,478.3	506.4
		Урт хугацаат өглөг	сая.төг	380,917.9	494,916.8	533,140.1	38,223.3	7.7	152,222.2	40.0
9	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	9,944.7	19,031.5	16,153.9	-2,877.6	-15.1	6,209.2	62.4
10	Нийт ажилтны тоо		хүн	1,286	1,305	1,299	-6.0	-0.5	13.0	1.0
11	Цалингийн сан		сая.төг	40,991.9	56,105.5	55,920.8	-184.7	-0.3	14,928.9	36.4

Компанийн хэмжээнд 2024 онд 8,310.0 сая. кВт.цаг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/ хүлээн авах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 8,330.1 сая.кВт.цаг ЦЭХ хүлээн авч, биелэлт 100.24 %-тай ба 7,919.7 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулах төлөвлөгөөтэй байснаас 8,024.7 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулж төлөвлөгөөний биелэлт 101.3%-ийн гүйцэтгэлтэй гарсан. 2023 оныг 2024 оны үзүүлэлттэй харьцуулахад дамжуулсан цахилгаан эрчим хүч 88,2 % буюу биетээр 3,89 тэрбум кВт.ц-ийн өсөлттэй, техникийн алдагдал биетээр 160,15 мян.кВт.ц буюу 55%, дотоод хэрэгцээ 2507,09 мян.кВт.ц буюу 18,3 % өссөн байна.

Компанийн 2024 оны дамжуулалтын алдагдлын хувь хэмжээг ЭХЗХ-ны 2023 оны 620 дугаар тогтоолоор 3.58% байхаар, 2024 оны 2-р улиралд ЦЭХ-ний төлөвлөгөөнд тодотгол оруулсанаар алдагдлын хувь хэмжээг 3,69% байхаар тус тус баталсан.

Техникийн алдагдалд 2016 онд 149,248.162 мян. кВт.ц зарцуулж байсан бол 2024 онд 289,512.8 мян.кВт.ц зарцуулж, ЦЭХ-ний дамжуулалт 140,264.660 мян.кВт.ц-аар өсөхөд дамжуулсан эрчим хүчний хэмжээ, шинээр агшиглалтад орсон дэд станц, агаарын шугамын алдагдлууд нөлөөлсөн.

Тайлант хугацаанд 557,152.2 сая төгрөгийн орлоготой, 559,386.5 сая төгрөгийн зардалтай, татварын дараахаар 2,238.0

сая төгрөгийн алдагдалтай, алдагдлын түвшинг 16,819.0 сая төгрөг буюу 88.3%-иар бууруулсан.

Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажилд 16,153.9 сая төгрөг зарцуулж, тайлант хугацаанд улсын төсөвт 94,390.3 сая төгрөгийг төвлөрүүлэн, татвар төлөгчийн хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан.

Компанийн худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр 100 хувь зохион байгуулсан.

Эрчим хүчний яамны дотоод аудитын хорооноос Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 2024 оны эцсийн байдлаар дүгнэхэд агуулга, стандартын дагуу тайлагнасан байдал 100%, тайлангийн илгээлтийн хувь хэмжээ 100 хувь гарч, өмнөх онтой харьцуулбал 10 хувиар нэмэгдүүлж, 100 хувийн үнэлгээ авсан.

Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас “Өөрчлөлтгүй” гэж дүгнэсэн.

ЗАХИРГАА УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

Компани 2024 онд дэвшүүлсэн 10 зорилт, 133 төлөвлөгөөт ажлыг 94.4 хувиар биелүүлж, удирдах байгууллагын 203 үүрэг даалгавар (ЭХЯ-с 151, ТӨБЗГ-с 16, ТУЗ-с 36) бүрэн хэрэгжсэн.

Хүний нөөцийн хомсдол, ажилтнуудын тогтвор суурьшлыг хангах зорилгоор ажилтнуудын цалин хөлсийг шат дараатай нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд ажилтны үндсэн цалинг дунджаар 7.5 хувиар нэмэгдүүлснээр өнгөрсөн онтой харьцуулахад өөрийн хүсэлтээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон ажилтны тоо 24 хувиар буурсан.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй “Сэргээгдэх эрчим хүчний оролцоо ихтэй эрчим хүчний системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл” төслийн хүрээнд 30 ИТА-г гадаад сургалтад хамруулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв.

Компани нь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-н “Монгол Улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг бэхжүүлэх”, “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт-2” төслийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдийг төвийн бүсийн түгээх, дамжуулах сүлжээнд холбох ур чадвар бүхий өндөр хүчдэлийн техникч бэлтгэх, мэргэжлийн практикт суурилсан хосмог сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажилтан ажлыг GIZ, ЭХЯ, БСШУЯ-тай хамтран 2024 оны 10 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд компанийн 37 ажилтан Налайх дүүрэг болон Дархан-Уул аймаг дахь Политехникийн коллежид суралцаж эхлээд байна.

Эрчим хүч импортлох тусгай зөвшөөрлийг 10 жилээр сунгуулж, ХЭМАБ-н MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 12 журмыг шинээр баталж, 2 журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Компанийн хэмжээнд мөрдөх технологийн картыг шинэчлэх ажлыг эхлүүлж, шугам тоноглолын угсралт, засвар, хэмжилт туршилтын ажлын технологийн карт, тусгай зориулалтын машин механизмын ажлын зааврыг боловсруулсан.

Компанийн нийт ажилтны 53 хувийг инженер техникийн ажилтан эзэлж байна. Ажилтнуудын дундаж нас 39 бөгөөд 68 хувийг 26-45 насны ажилтнууд эзэлж байна. Компанийн нийт ажилтны 29.7 хувийг эмэгтэй ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан 1.9 хувийг, өрх толгойлсон ажилтан 8.2 хувь байна. Ажилтнуудын 72 хувь нь дээд боловсрол эзэмшиж, 18 зөвлөх, 60 мэргэшсэн инженер, нягтлан бодогч, төсөвчин байна. Компанийн нийт орон тооны 54 хувийг шуурхай ажиллагааны ажилтнууд эзэлж байна. Хүний нөөцийн бүрдүүлэлтийг орон тооны батлагдсан хязгаарт багтаан хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, 146 ажилтанг ажилд шинээр авч, 66 ажилтан албан тушаал дэвшин 120 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн байна.

Компанийн хамт олны дундаас “Аж үйлдвэрийн гавьяат ажилтан” төрж, 2 ажилтан Техникийн ухааны докторын зэрэг хамгаалсан.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Компанийн үйл ажиллагаанд ХАБЭА-н хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэд станц, шугам тоноглолын техникийн аюулгүй байдлыг хангаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, компанийн технологийн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалт хийж, зөвлөмж, дүгнэлт гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

“ХАБЭА-н тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийг хэн сайн мэдэх вэ” сэдэвт тэмцээнийг Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилтнуудын дунд амжилттай зохион байгуулсан.

Эрчим хүчний хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд 35, 110, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын “Хамгаалалтын зурвас”-т 2023 онд 1171 айл өрх, аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэх хуудас, албан шаардлага хүргүүлсэн бол 2024 онд 1111 болж буурсан.

Компанийн зарим нэгж, салбарын үйл ажиллагаанд дотоод аудит зохион байгуулж, тайлан, баримт бичгийн хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, ажлын төсөв, гүйцэтгэл, худалдан авалтын гэрээ, гүйцэтгэл, баримт бүрдэл, мөнгөн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, материал, сэлбэг хэрэгслийн бүртгэл, үлдэгдэл нөөцийн байдал, орон тоо, цалин хөлсний баримт, бодолт зэргийг хянан шалгаж, 39 зөрчлийг илрүүлж, 100 хувь арилгуулав.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл ба боломжуудыг удирдах тогтцоор хангах үүднээс Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 27-р тогтоолоор баталсан MNS ISO 45001:2018 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо Шаардлага, хэрэглэх заавар” стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. ISO 45001:2018 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд ХАБЭА-н бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг шинэчилж, 24 ажилтан дотоод аудиторoor бэлтгээд байна.



ТЕХНИКИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

Дамжуулах сүлжээг Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа-2050” бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөр, шинэ бүтээн байгуулалт, салбарын бодлоготой уялдуулан хөгжүүлэх, өргөтгөх судалгаа тооцоо хийх, техникийн хүндрэлтэй асуудлыг нарийвчлан судлах, эдийн засгийн үр ашиг, найдвартай ажиллагааг дээшлүүлэхэд санал, дүгнэлт гаргах, шаардлагатай хөрөнгө оруулалтын үндэслэл, тооцоо, зураг төслийг боловсруулахад хамтран ажиллаж байна.

Тайланд хугацаанд Төвийн бүсийн эрчим хүчний системийг Дорнод бүсийн эрчим хүчний системээс тусад нь гаргаж, 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станцын зарим хэрэглээг Дорнод бүсийн эрчим хүчний системээс хангах схемийн шийдлийг санаачилж, ажлын зураг төсөл боловсруулан барилга угсралтын ажил дууссан.

220 кВ-ын 207-р шугамын тасралт, таслалтын судалгаа, засвар үйлчилгээ хийхэд зарцуулдаг хугацаа, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, байгаль орчны үнэлгээг эцэслэж, Багануур-Чойрын агаарын шугамын байгаль орчны үнэлгээний тайланг БОАЖЯ-аар баталгаажуулсан.

Сонгино дэд станцыг түшиглэн байгуулсан том чадлын хуримтлуурын станцын 3 төсөл хэрэгжүүлэх ажлын саналыг ЭХЯ, төслийн нэгжид хүргүүлэн ТЭЗҮ боловсруулав.

Нийслэлийн төвийн хэсгийг цахилгаан эрчим хүчээр хангаж буй 110/10/6 кВ-ын Өмнөд, 110/10/6 кВ-ын Умард, 110/35/10 кВ-ын Дорнод-2, 110/35/10 кВ-ын Туул дэд станцууд сүүлийн 5 жилийн байдлаар 70-100 хувийн ачаалалтай ажиллаж ирсэн тул хотын төвд томоохон чадлын 110 кВ-ын дэд станц барих шаардлага гарч, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн хашаан дотор шинээр 110/10 кВ-ын 2х63 МВА хүчин чадалтай 110 кВ-ын GIS хийцтэй хаалттай хуваарилах байгууламж бүхий Парк дэд станцыг барихаар төлөвлөж, 2024 оны 11-р сараас эхлэн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна.

Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Хөвсгөл, Завхан /хэсэгчлэн/, Говь-Алтай /хэсэгчлэн/, Сэлэнгэ /зарим сум/ Дундговь /зарим сум/, Өмнөговь /зарим сум/ зэрэг 11 аймгийн 154,430 хэрэглэгчийн ЦЭХ-ний хэрэглээний өсөлтийг хангаж, хоёр талын тэжээлтэй болгож найдвартай ажиллагааг дээшлүүлэх зорилгоор Мандалговь-Арвайхээр 220 кВ-ын 287 км урт ЦДАШ, дэд станц барих төслийн ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулагдсан. Цаашид 3,7 тэрбум кВт.цаг ЦЭХ дамжуулах хүлээлттэй байна.

Хотын хойд хэсэг, гэр хорооллыг инженерийн дэд төвд холбох, барилгажуулах зорилгоор

- Сүхбаатар дүүрэг, 17-р хороо, Дамбадаржаа 110/35/10 кВ-ын 2х40 МВА хүчин чадалтай дэд станц, ЦДАШ,
- Сонгинохайрхан дүүрэг 26-р хороо, 2х40 мВа /GIS/ 110/35/10 кВ-ын Их Наран дэд станц, ЦДАШ барих
- Сонгинохайрхан дүүрэг 24-р хороо, 2х40 мВа чадалтай 110/35/10 кВ-ын /GIS/ Баянхошуу дэд станц, ЦДАШ барих ажлын зураг төсөл хийгдээд байна.

Өвөл зуны горим боловсруулах, шинэ эх үүсвэр, хэрэглэгчдийг ТБЭХС-тэй холбох бүхий л тооцоог Powerfactory программ дээр гүйцэтгэж, 82 дэд станцад техникийн нөхцөлийн ачааллын судалгаа, шинээр ачаалал нэмэх боломжийг судалсан. Түүнчлэн


- Компанийн Даланзадгад, Өндөрхаан, Бор-Өндөр, Мөрөн, Баянхонгор дэд станцын трансформаторыг өргөтгөх

- Багануурт баригдаж байгаа 50/200МВт.цаг хүчин чадалтай батарей хуримтлуурын станцын өвөл, зуны горимд ажиллах
- КАСЭН ПАУЭР ГРИЙН ЭНЕРЖИ ХХК-ийн санхүүжилтээр Багахангай дүүрэгт баригдах 2*330мвт чадалтай ДЦС-ыг ЭХС-д холбох
- Райд монголиа ХХК-ийн санхүүжилтээр Сэлэнгэ аймаг, Сүхбаатар хотод баригдах 70 МВт-ын ДЦС-ыг ЭХС-д холбох
- ДЦС-2-ын 0,4/6 кВ-ын шинийн хэрэглэгчдийг шилжүүлэх
- 220 кВ-ын 225-р ЦДАШ-ыг хоёр хэлхээ болгож өргөтгөх үеийн горимыг тооцоолсон байна.

ТЗБАХ-ээр хийгдэх ажлын зураг төсөл боловсруулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай дэд станц, ЦДАШ-ын зураг төсөлд хамтран ажилласан.

Цахилгаан эрчим хүчний баланс


Нийт алдагдлын 40 хувийг 220 кВ-ын шугам сүлжээ, 57 хувийг 110 кВ-ын шугам сүлжээнд зарцуулсан байна.



Дамжуулалт төлөвлөснөөс 13,7 сая.кВт.цаг ЦЭХ-ээр нэмэгдсэн.

Дотоод хэрэгцээг төлөвлөснөөс 0,05 бууруулж, 1,5 сая.кВт.цаг ЦЭХ-ээр буурсан.

Нийт алдагдлын 40 хувийг 220.кВ-ын.шугам сүлжээ, 57 хувийг 110 кВ-ын шугам сүлжээнд зарцуулсан буурсан.



ЭХЗХ-оос 2025 оны ДА-ын хувь хэмжээг 3.61% байхаар хэлэлцэж баталсан.

ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТ

ЦДҮС ТӨХК-ийн 220/110/35/10/6 кВ-н 82 дэд станц, 220/110/35 кВ шугам, тоноглолын тасралтгүй найдвартай ажиллагааг ханган, өдөр тутмын горим ажиллагаанд тогтмол хяналт тавьж, зохицуулалт хийж, шуурхай ажиллагааны хүмүүсийг нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан.

Өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд 220/110 кВ-н 13 ЦДАШ, 8 дэд станцыг шинээр хүчдэл дор залгах, 5 дэд станцын 8 хүчний трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Сонгино, Эрдэнэт, Багануур, Тавантолгой, Оюутолгой, Мөрөн, Сансар, Хөшигт, Багахангай, Өндөрхаан, Баянхонгор, Цэвэрлэх, Илчбаян, Даланзадгад дэд станцын тоноглолын шинэчлэлтийн ажилтай холбогдуулан ажлын байр бэлдэх, хүчдэл дор тавьж, ачаалал өгөх, сэлгэн залгалтын хөтөлбөр, сэлгэн залгалтын хуудаст хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэж, сэлгэн залгалтыг удирдан зохион байгуулж ажилласан.

Компанийн хэмжээнд 3776 ажлын захиалгыг хүлээн авч, диспетчерийн болон горимын зохицуулалт хийж ажилласнаас ДҮТ-ийн удирдлага, мэдлийн тоноглолтой холбоотой 1257, компанийн болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидийн удирдлага мэдлийн тоноглолтой холбоотой 2519 захиалга байна. 2023 оны захиалгаас ДҮТ-н захиалга 185-аар, компанийн захиалга 577-аар нэмэгдсэн байна.


Компанийн хэмжээнд 2024 онд 8,310.0 сая.кВт.цаг ЦЭХ хүлээн авах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 8,330.1 сая.кВт.цаг ЦЭХ хүлээн авч, биелэлт 100.24 %, 7,919.7 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулах төлөвлөгөөтэй байснаас 8,024.7 сая.кВт.цаг ЦЭХ дамжуулж, төлөвлөгөөний биелэлт 101.3% гүйцэтгэлтэй гарсан.

Дамжуулалт өссөн нь:


1. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэлийн болон аймгийн төв, 10.000 дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай ЭХЗХ-ны 724-р тогтоолыг хэрэгжүүлэн ажилласантай холбоотой өссөн.
2. Уул уурхайн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөнтэй холбоотой байна.

2024 онд 220/110/35/10/6 кВ-н нийт 887 тасралт гарснаас 1155 мян.кВт.цаг ЦЭХ-ийг дутуу түгээсэн. Өмнөх онтой харьцуулахад тасралтын тоо нэмэгдсэн боловч, дутуу түгээсэн ЦЭХ-ий хэмжээ 80 хувиар буурсан. ЦЭХ дутуу түгээхэд тоноглолын хуучралт, байгалийн давагдашгүй хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлсөн.

Нийлмэл сэлгэн залгалтын тоо




Сэлгэн залгалтын тоо




Импорт, экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл

Нийт алдагдлын 40 хувийг 220 кВ-ын шугам сүлжээ, 57 хувийг 110 кВ-ын шугам сүлжээнд зарцуулсан байна.



Хамгийн олон тасарсан ЦДАШ



РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТИК, ХЭМЖИЛТ ТУРШИЛТ

Реле хамгаалалт, автоматжуулалт, өндөр хүчдэлийн туршилт хэмжилт, тоолуур, хэмжүүр болон тавил тооцоо, оношилгоо диагностикийн чиглэлээр баримтлах бодлогыг тодорхойлж, реле хамгаалалт автоматжуулалт, автомат удирдлагын системийг нэвтрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, РХАБ, хэмжүүр тоолууруудын хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцын 110 кВ-н Сийрст-А,Б гаргалгааны хоёрдогч хэлхээний кабель татах, хоёрдогч хэлхээний холболт хийх, харилцан үйлчлэл шалгах, тоноглолд хэмжилт туршилт хийх ажлыг хийж гүйцэтгэв.

110/35/10 кВ Даланзадгад дэд станцын давтамжаар ачаалал хөнгөлөх автоматикт илэрсэн зөрчлүүдэд зохион байгуулалтын арга хэмжээг авч, дэд станцын 10 кВ-ын I секц Т-4 трансформатор, II секцийн Т-5 трансформаторуудын ячейкуудад ТА-ийн төхөөрөмжийг шинээр суурилуулж, холболтын ажлыг гүйцэтгэсэн. Шинээр суурилуулсан төхөөрөмжид Даланзадгадын ДЦС-ын тусгаарлах автоматикийн I, II шатлал болон АЧР-ын тавилуудыг тооцож, туршилт тохируулгыг хийв.

Салхит дэд станцад ээлжит реле хамгаалалтын үзлэг, шалгалтаар 110/35 кВ Салхит дэд станцын Т-1, 2 трансформаторын үндсэн болон бэлтгэл хамгаалалт, 123, 124-р АШ, 35 кВ-н СВК-1,2, НУО-1,2, ДХТ-1,2, Багц-1,2,3,4-н реле хамгаалалтыг таслууртай харилцан үйлчлүүлж шалгасан байна.

ЗӨБС-т хэмжүүрийн трансформатор шалгаж, баталгаажуулах олон жилийн графикийн дагуу 220/110/35/6 кВ-ын Чойр, 110/35/10 кВ-ын Айраг, 110/35/10 кВ-ын Сайншанд, 110/10 кВ-ын Ширээт, 110/10 кВ-ын Замын-Үүд, 110/10 кВ-ын Борхойн дэд станцуудад 35,10,6 кВ-н гарсан шугамуудын гүйдэл, хүчдэлийн трансформаторуудад алдааны хэмжилт, туршилтыг хийж гүйцэтгэв.

Төвийн бүсийн салбарын хэмжүүрийн трансформатор шалгаж, баталгаажуулах олон жилийн графикийн дагуу 110/10 кВ-ын Дулаанхаан, 110/35/6 кВ-ын Сүхбаатар, 110/10 кВ-ын Ерөө, 110/6 кВ-ын Бугант, 110/6 кВ-ын Толгойт, 110/6 кВ-ын Үйлдвэр, 110/6 кВ-ын Бурхант дэд станцуудад 35,10,6 кВ-ын гарсан шугамуудын гүйдэл, хүчдлийн трансформаторуудад алдааны хэмжилт, туршилтыг хийж гүйцэтгэв.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ


Компьютерийн сүлжээ, халдлага илрүүлэх системүүд, хяналтын камерын систем, компанийн интернет, технологийн тусгай зориулалтын сүлжээ, дотоод сүлжээ, VPN сүлжээ, SCADA, WAMS системийн програм хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг хангалаа.

Компанийн хэмжээнд Microsoft 365 системийг premium багцаар нэвтрүүлж, компанид үүсдэг олон хүндрэлийг цогцоор нь шийдэв.

2023 оноос хөгжүүлсэн Дата менежмент систем буюу Дашбоардыг сайжруулж боловсронгуй болгох үүднээс RPA системтэй хослуулан хөгжүүлэхээр ажиллаж байна. Уг системийг сайжруулснаар өмнөх хувилбар дээр хийгддэг байсан гар ажиллагааг хөнгөвчилж, хийгддэг процессийг роботын тусламжтай гүйцэтгэснээр цаг хугацаа хэмнэх болон хүний гаргадаг алдаа дутагдлаас сэргийлэх боломжтой болсон.

Компанийн хэмжээнд СКАДА систем нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэн өмнө нь холбосон УБС-н 12 дэд станц дээр УБС-н 13, ГБС-ын 4 дэд станцыг холбож, 31 дэд станцыг холбох нөхцөл бүрдсэн.

2024 онд холбооны тоног төхөөрөмжүүд шинэчлэгдэж SIP холбоо, радио холбоо шинээр нэвтэрч, “Орон нутгийн холбоог нэгдсэн сүлжээнд холбох” ажлын хүрээнд компанийн холбооны нэгдсэн сүлжээ үүсгэж, бүх дэд станц, салбаруудад нэвтрүүлж, SIP холбоогоор холбогдсоноор технологийн сүлжээ үүсгэж, СКАДА системийг компанийн хэмжээнд нэвтрүүлэх бүрэн боломжтой боллоо.



ЗАСВАР ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаа, тооцоо, диагностик оношилгоог үндэслэн тоноглолын засварыг оновчтой төлөвлөж, зохион байгуулах, чанар, биелэлтэд хяналт тавих шинэ дэвшилтэд техник технологи, арга барилыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд их засварын 216, ТЗБАХ-ний 40, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 56 буюу нийт 312 нэр төрлийн ажил төлөвлөснөөс 310 ажил бүрэн дуусаж, гүйцэтгэл 99.4 хувьтай байна.

Тайлант жилд их засварын ажлаар дараах томоохон ажлыг гүйцэтгэсэн:

- 110/10 кВ-н Буянт-Ухаа 40МВА чадалтай, SFZ10-40000/110 маркийн Т-1 трансформаторын гэмтэл устгах,
- ИХБ-3-ын Т-2 хүчний трансформаторын засвар үйлчилгээ хийх
- АШ-208, 225, Өндөрхаан, Дулаанхаан зэрэг агаарын шугамуудад ашиглалтын шаардлага хангахгүй цууралт, гажилт өгсөн завсрын төмөр беон тулгуурыг солих
- Үер усны гамшгийн улмаас унасан АШ-121, 122-ын тулгуур №108-ыг сэргээн засварлах.
- 110 кВ-ын Тэлмэн агаарын шугамын алгасалт ихтэй цэгүүдэд нэмэлтээр дундын 5 тулгуур босгох
- Хархорин агаарын шугамд анкерын алгасалт ихтэй, салхины урсгалтай хэсэгт 2 анкер тулгуур босгох
- Өмнөд дэд станцын 110/10/6кВ-ын бүх тоноглолын РХА-ын төхөөрөмжийг хоёрдогч хэлхээний хамт иж бүрэн шинэчлэх
- Ачаалал хөнгөлөх автоматжуулалтын системд өндөр ачаалал бүхий дэд станцуудыг холбох, системийн аюулгүй найдвартай байдлыг дээшлүүлэв.

220 кВ-ын 216-р АШ-н 1 ба 3-р фазын хөндийрүүлэх гирлянд хүчтэй салхины

улмаас хазайж дамжуулагч утас тулгуурт ойртонтасралтих гарч байгаа тул тус АШ-н 1 ба 3-р фазын гирляндны скобыг хасах, чичиргээ намдаагч шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Шинээр баригдаж буй 220 кВ-ын 3-р Оюу хуваарилах байгууламжийг төвийн эрчим хүчний системтэй холбох 220 кВ-ын 219, 220-р АШ-ын трасс өөрчилж, шинээр 3 км шугам барих барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

110/35/10 кВ-ын Даланзадгад дэд станцын 25МВА чадалтай, ТДТН 25000/110-У1 маркийн Т-1, Т-2 хүчний трансформаторын их засвар, тээвэрлэлт суурилуулалт, дэд станцын тоноглол өргөтгөн шинэчлэх ажил хийж гүйцэтгэсэн.

Компанийн үйл ажиллагаанд ашиглаж буй цахилгаан тоноглолын тусгаарлах тосны чанарыг тодорхойлох, тоноглолын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, гэмтлийг оношилох зорилго бүхий тосны химийн лабораторид 2024 онд 364 удаагийн шинжилгээг хийж баталгаажуулсан. Тус лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлага хангасан итгэмжлэгдсэн лаборатори болохоор бэлтгэлийг хангаж байна.



ШИЛДЭГ 10 АЖИЛ

1. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд Цэвэрлэх, Баянхонгор, Өндөрхаан, Даланзадгад, Мөрөн дэд станцуудад өргөтгөл шинэчлэлтийг хийж, суурилагдсан хүчин чадлыг 126,3 МВА-р нэмэгдүүлсэн.



Өндөрхаан дэд станц



Даланзадгад дэд станц



2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд 300 МВт-н Бөөрөлжүүт цахилгаан станцын 220 кВ, газрын тос боловсруулах үйлдвэрийн өргөх станцын 110 кВ, Нарийнсухайт – Баянхөндий чиглэлийн 110 кВ-ын ЦДАШ-уудын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, 50 МВт-н чадалтай Багануур “Батарей хуримтлуурын станц”-ыг эрчим хүчний нэгдсэн системд залган зүгшрүүлэлтийг хийсэн. 10 МВт-н “Хөвсгөл нарны цахилгаан станц”-ын төслийн хүрээнд 110/35/6 кВ-н Мөрөн дэд станцын 110 кВ талын өргөтгөл, БНХАУ-аас ЦЭХ импортлох 220 кВ-ын “Зэс Оюу” хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажилд компанийн инженер техникийн ажилтнууд ур чадвараа гарган ажилласан.

3. Агаарын шугамын тасралт, саатлыг бууруулах зорилгоор 220 кВ-ын 216, 110 кВ-ын Тэлмэн, Бор-Өндөр, Арвайхээр агаарын шугамын утасны унжилтын зайг багасгах, замын давуулгуудад нэмэлт дундын тулгуур босгох, тулгууруудыг хүчитгэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэснээр утасны алслалтыг норм хэмжээнд хүргэн утасны гэмтлийг багасгаж, тасралтын тоог өмнөх оноос 20,7 хувиар бууруулсан. Ингэснээр тулгуур унах эрсдэл, гарч болзошгүй аваар саатлаас урьдчилан сэргийлж, шугамын үзлэг, үйлчилгээ, засвар хийхэд хялбар болсон.



4. 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 110/10 кВ -ын 40 МВА хүчний трансформаторын их засварын ажлыг хийж дуусгасан.



- Систем Улаанбаатар График

Дэд стан Тахил Дүнхонд

Нийт хэрэглээ : 1475.4 MВт
Импорт/Экспорт : -280.5 MВт
Давтамж : 50.0 Гц

2:18:20 PM 12/18/202

36.0 MВт 36.0 DOM AM Ажлын СХД

P FLOW THERM CEX Улаанбаатар Дүнхонд

Системийн нийлбэр 1475.4 MВт

Импорт / Экспорт -280.5 MВт

НЦС нийлбэр 15.0 MВт

СЦС нийлбэр 84.9 MВт

ДЦС-4 722.8 MВт

ДЦС-3 146.6 MВт

ДЦС-2 23.0 MВт

Улаа Худал ЦС 18.0 MВт

ГӨЖ ДЦС

Дархан ДЦС 71.6 MВт

Эрдэнэт ДЦС

Сонгодо БХС

80
40
0
-40

-



8. Ажилтнуудын ажлын байрны тав тухтай байдлыг сайжруулах чиглэлээр Улаанбаатар салбарын лабораторийн хоёр давхар барилгыг шинээр ашиглалтад оруулж, тус салбарын Өмнөд, Туул, Баруун, Умард дэд станцуудад ариун цэврийн өрөөний асуудлыг шийдсэн.



9. ЦДАШ болон дэд станцын тоноглолын угсралт, засвар, хэмжилт туршилтын 17 нэр төрлийн ажлын аргачлал боловсруулан батлуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. MNS ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, Хамгаалалтын зурваст хууль зөрчин аюул, эрсдэлтэй нөхцөлд үйл ажиллагааг явуулж, амьдран суудаг 100 гаруй айл өрх, ААН-ийн газрыг бүрэн чөлөөлөх, нөхөн төлбөр ногдуулах, барагдуулах, мэдээллийн санд шугам, дэд станцын байршлын цэгүүдийг тусгаж ажилласан.

10. Компанийн хамт олны дундаас “Аж үйлдвэрийн гавьяат ажилтан” төрж, 2 ажилтан маань “Техникийн ухааны доктор”-ын зэрэг хамгаалсан. Сургалтын чиглэлээр гаднын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, JICA-н төслийн хүрээнд 30 ИТА-г гадаад сургалтад хамруулж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэв. Монгол Улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг хөгжүүлэх (МУТЭХЧ) төсөл”-ийн хүрээнд “Өндөр хүчдэлийн техникч” мэргэжлээр хосмог сургалт зохион байгуулах санамж бичгийг GIZ-тэй байгуулж, төслийн ажлыг эхлүүлээд байна.



GIZ-тэй Санамж бичиг байгуулав



Жайка SWC багуудын сургалт

2024 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ



БИЕЛЭЛТ /133 АРГА ХЭМЖЭЭ/ 94.4%

2025 ОНЫ ЗОРИЛТ

- 1 2025 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлэх
- 2 Осол авааргүй ажиллах
- 3 Монгол Улсын Засгийн Газраас 2025 оны Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжилд дэмжлэг үзүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор 2035 он хүртэлх Улаанбаатар хотын дамжуулах сүлжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх
- 4 Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон ХБНГУ-ын KfW банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл”-ийн угсралтын ажлыг 50% буюу түүнээс дээш гүйцэтгэлд хүргэх, Чойр-Сайншанд ЦДАШ, 110/10 кВ-ын “Өргөө” дэд станцын төслүүдийг эхлүүлэх
- 5 Компанийн хэмжээнд дижитал шилжилтийг хурдасгах хүрээнд SCADA системийг өргөтгөх, хяналтын самбар (Dashboard), ухаалаг тоолуур, хэмжүүр болон тоон дэд станцын технологийг нэвтрүүлэх
- 6 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд болон батарей хуримтлуурын станцыг үр ашиг, үйлдвэрлэлийн өгөгдөл дээр дүн шинжилгээ хийж, дамжуулах сүлжээний ногоон эрчим хүчний оролцоог нэмэгдүүлэх
- 7 Дамжуулах сүлжээнд инноваци шинэ техник технологийг нэвтрүүлэх хүрээнд 500 кВ-ын ЦДАШ, дэд станц, PASS систем, E-HOUSE зэрэг дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх
- 8 Зэс-Оюу 220 кВ-ын ИХБ-ийг барьж, ашиглалтад оруулах замаар БНХАУ-ын ӨМӨЗО-оос импортлох цахилгаан эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх
- 9 2025 оны эрчим хүчний салбарын хэмжээнд “Салбарын инженер техникийн ажилтан, албан хаагчдын жил” болгон зарласантай холбоотойгоор хүний нөөц чадавх, сургалт бүтээмжийг чанарыг дээшлүүлэх
- 10 Компанийн үйлчлэх хүрээг нэмэгдүүлэх, засаглалын менежментийг сайжруулахад олон улсын стандартыг нэвтрүүлэх

